

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

**БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго тэргүүлэх чиглэл, төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, зэргийг төвийн ажилтан, албан хаагч нар уншиж танилцах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор байгууллагын дотоод сүлжээ, www.ehemut.mn цахим хуудсанд хууль, эрх зүйн буланд байршуулсан.	100%
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах, утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх, нийгмийн сүлжээний хаяг	Тус төвийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн тухай мэдээлэл нь www.ehemut.mn цахим хуудасны Нүүр хуудас – Танилцуулга – Бүтэц зохион байгуулалт – Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв: ТӨВИЙН ДҮРЭМ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ файлд байршуулсан. Мөн www.ehemut.mn вебийн Нүүр хуудасны хөл хэсэгт /доор/ Төвийн байрлал, утасны дугаар, шуудангийн хаяг, нийгмийн сүлжээний хаяг зэрэг мэдээллүүд байрлаж байна.	100%
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт – шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага зөвлөмж	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Хандив, тусламжийн орлого, Хандив, тусламжийн	100%

		зарцуулалтын тайлан мэдээллийг тухай бүр шилэн данс, шилэн ажиллагаанд тус тус байршуулсан. - Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шилэн данс, шилэн ажиллагаанд тус тус байршуулсан. Аудитын зөвлөмж, албан шаардлагын биелэтийг гарган шилэн данс, шилэн ажиллагаа болон аудитын нэгдсэн мэдээллийг санд илгээсэн. - Байгууллагын вэб хуудсанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр байршуулж, 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг аудитын зөвлөмж, дүгнэлтийн хамт байршуулсан. - Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг сар болгон гаргаж ЭМЯ-нд цаасаар болон цахимаар шивж илгээж байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ЭМЯ-нд нэгтгүүлсэн.	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	- Төв нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна. 2025 онд хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллахад гарсан сөрөг үр дагавар, хүндрэл бэрхшээлгүй байна.	100%
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хөгжлийн төлөвлөгөөг 2013-2016, 2017-2020, 2020-2023, 2023-2026 оноор 4 удаа, дунд хугацааны стратеги, төлөвлөгөөг 2011-2016, 2017-2019, 2020-2023, 2023-2026 онуудад тус бүр 4 удаа боловсруулан мөрдөн ажиллаж байна. - ЭХЭМҮТ-с 2023-2026 онд хэрэгжүүлэх дунд хугацааны Стратеги, төлөвлөгөө 5 үндсэн чиглэл, 8 стратегийн зорилго, 22 стратегийн зорилттой боловсруулагдсан. Тус стратегийн зорилтод дэвшүүлэгдсэн 75 ажлаас 80-99%-н биелэлттэй ажил 2023 онд 4, 2024 онд 2 байсан бол 100% ба түүнээс дээш биелэлттэй ажил 2023 онд 55, 2024 онд 57 байна. 2025 оны 12 дугаар сард 2025 оны гүйцэтгэлийн тайлангаар хэрэгжилтийн хувь нэгтгэгдэн гарна.	100%
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн	Төв нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:	100%

	газрын шийдвэр бусад эрх зүйн акт	• Монгол улсын хууль ✓ Төсвийн тухай хууль ✓ Хөдөлмөрийн тухай хууль ✓ Төрийн албаны тухай хууль ✓ Эрүүл мэндийн тухай хууль ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ✓ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай • Засгийн газрын тогтоол ✓ 2024 оны 238 дугаар тогтоол ✓ 2024 оны 84 дүгээр тогтоол ✓ 2018 оны 382 дугаар тогтоол ✓ 2022 оны 491 дүгээр тогтоол ✓ 2019 оны 05 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажиллаж байна. • ABLE программууд болон цахим хаяг ашиглан төвд ирсэн, явсан албан бичгүүдийг кодлон, бүртгэлийн дугаар өгч баримтжуулж байна. • Байгууллагын дотоод цахим хуудас болон дотоод сүлжээнд шинэ журам, журамд орсон өөрчлөлт бүрийг тухай бүрт байршуулан, мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.	
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг эхийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	• www.ehemut.mn веб хуудасны ТАНИЛЦУУЛГА цэсийн Бүтэц зохион байгуулалт дэд цэсэнд “АЛБА”, “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМНЭЛЭГ”, “ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ”, “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, ГАДААД ХАРИЛЦАА”, “ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА”, “ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ИНЖЕНЕР ТЕХНИК” бүлгүүдэд тус төвийн бүх тасаг нэгжүүдийн танилцуулгыг байршуулсан. Танилцуулгаас тухайн нэгжийн товч түүх, үйл ажиллагааны чиглэл, бүрэлдэхүүн ба холбоо барих албаны цахим шуудангийн хаягийн мэдээлэл авч болно. Нийт 59 нэгжийн мэдээлэл байна.	100%
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	✓ 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус төвд ЭМЯ, ЭМГ болон холбогдох яам, газруудаас нийт 1209 албан бичиг ирсэн байна. Үүнээс: ➢ ЭМЯ-наас 295 ➢ Сайдын тушаал, албан даалгавар-32	100%

		➤ Өргөдөл, хүсэлт-118 ➤ 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 11-11 төвөөр нийт 265 өргөдөл, гомдол, хүсэлт, талархал ирсэн байна. Үүнээс Дэмжлэг хүсэхтэй холбоотой 76, бусад-109, талархал-80 байна.	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	✓ "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" ЭМС-ын А/611 тоот тушаалын дагуу анхан шатны маягтуудыг захиалан төвийн бүх тасаг нэгжүүдийг анхан шатны маягтаар хангаж, маягтын хөтлөлтөнд хяналтыг тогтмол хийн гарсан зөрчлийг тухай бүр залруулж ажилласан. ✓ "Цахим эрүүл мэнд" төслийг хэрэгжүүлэх үүднээс өглөө бүр тасгуудын орны хөдөлгөөний мэдээг авч, гарсан өвчний түүхийг ehealth програмд шалган, хаагдаагүй тохиолдлыг эмч нарт буцааснаар програмын алдааг арилгаж ажилласан. Эхний 10 сарын байдлаар нийт 88 түүхийг буцааж, цахимд хаалгасан байна. ЭМС-ын А/611 тоот тушаалын дагуу цахим өвчний нийт 21834 түүх, төрөлтийн 7044 түүх, мөн нас баралтын 320 түүхийг цахим түүхээс цаасан хэлбэрт шилжүүлэн хэвлэсэн. ✓ ЭХЭМҮТ-ийн эрүүл мэндийн үзүүлэлтийн мэдээг сар, улирал, эхний хагас жил, 3-р улирал нийт 10 удаа төвийн цахим хуудсанд байршуулсан. ✓ ЭМС-ын 2022 оны А/263 тоот тушаалаар батлагдсан "Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай" журмын хүрээнд 2025 оны 1-2-р улирал, эхний хагас жилийн эндэгдлийн мэдээллийг боловсруулан ЭМТҮЧАБА болон эмчилгээ эрхэлсэн дэд захирлуудад мэйл хаягаар илгээж магадлан хэлэлцэх комиссын хуралыг зохион байгуулсан. ✓ Хорт хавдрын анх оношлогдсон тохиолдол бүрийг ЭМС-ын А/611 тоот тушаалын Н-info-3.0 програмд шивж оруулан цахим мэдээллийн сан үүсгэсэн. 2025 оны эхний 10 сарын байдлаар 71 шинэ хавдрын тохиолдлыг ХСҮТ-д мэдээлсэн.	

		✓ Шинээр төрсөн нярайд регистрийн дугаар буруу олгосонтой холбоотой /СТ-4 маягт/ 8 алдааг ЭМДЕГ-ын цахим мэдээллийн хэлтсээр дамжуулан УБЕГ-аас хасалт хийлгэсний дараа дахин регистр үүсгэсэн. Мөн цахим эмнэлгийн хуудастай холбоотой гарсан нийт 191 зөрчлийг тухай бүр эмчлэгч эмчтэй нь холбогдон засаж залруулсан. ✓ Тмнэлгийн хуудас цахим хэлбэрт 2022 оноос шилжсэн ба жирэмсний болон амаржсаны нийт 4491, хөдөлмөрийн чадвар түр алдалтын 1144 хуудсыг цахимаар илгээсэн. ✓ Шинэ төрсөн нярайд регистрийн дугаар үүсгэхтэй холбоотой төрөх тасагт бүртгэл үүсээгүй 126 тохиолдлыг health.gov.mn програмд шивж оруулсан. ✓ Мэдээ мэдээллийн шуурхай байдлыг хангах үүднээс орны хөдөлгөөний мэдээг тасаг нэгжээс өглөө бүр авч хоолны мэдээг нэгтгэн цахимаар болон цаасан хэлбэрээр ЭХСТ-т илгээж ажилласан. ✓ ЭМС-ын 2014 оны 358 тоот тушаалын дагуу ТТТӨ-ийн мэдээг нийт 46 удаа, амбулаторид суурилсан тохиолдлын тоог өдөр бүр www.flu.mn-ээр тасралтгүй мэдээлсэн. ✓ ЭМС-ын 2025 оны А/420 тоот тушаалын дагуу эх, нярайн өвчлөл, эндэгдэлтэй холбоотой тандалтын мэдээллийг 7 хоног тутам нэгтгэн ЭХЭМҮТ-ийн ТСА-нд нийт 47 удаа, ЭМХТ-ийн ЭММА-нд статистикийн мэдээ, мэдээллийг сар бүр нэгтгэн нийт 10 удаа, ГССҮТ-ийн “Осол гэмтлийн тандалтын удирдамж”-ийн сарын мэдээний маягтын дагуу осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээг сар бүр www.gemteltandalt@gmail.com цахим хаягаар нийт 10 удаа тус тус мэдээлсэн. ✓ Угаарийн хийн хордлого болон эм, химийн бодисын хордлогын улмаас ХЭ-ийн ЯТТ-аар үйлчлүүлсэн 0-16 насны хүүхдийн дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухайд нь өдөр бүр илгээсэн. ✓ НЭМГ-т статистикийн мэдээ мэдээллийг сар бүр нэгтгэн, нийт 10 удаа, ЭМС-ын 2020 оны А/478 дугаар тушаал “Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг утсаар зохицуулах журам”-ын дагуу тус төвийн үзлэгийн цаг товлох үйлчилгээний нэгтгэлийг ЭМХТ-д сар бүр албан тоотын хамт нийт 10 удаа тус тус илгээсэн.	
--	--	---	--

		✓ ЭХЭМҮТ-д 2025 оны эхний 10 сарын бадлаар 28878 эх, хүүхэд, эмэгтэйчүүд хэвтэн эмчлүүлсэн ба СМТ-ийн архивт 7044 төрөлтийн болон 21834 өвчний түүх, 320 нас баралтын түүхээр мэдээллийн сан үүсгэн, хадгаламжийн нэгжийг тасаг, нэгж тус бүрээр бүртгэлжүүлж, архивласан. ✓ 2024 оны мөн үетэй харьцуулбал төрөлт 291 тохиолдлоор буурсан, хэвтэн эмчлүүлэгсэд 770 тохиолдлоор, нас баралт 28 тохиолдлоор тус тус өссөн байна.	
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	• 2025 оны Тендерийн нээлттэй заруудыг www.tender.gov.mn, ehemut.mn вэб сайт дээр байршуулсан. • 2025 онд зохион байгуулсан сургалт, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн талаарх зарлал мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн вэб хуудас, Төвийн пэйж хуудсаар нийтэд нээлттэй мэдээллэж ажилласан. • 2025 оны 11 сарын байдлаар Төвийн пэйж хуудсаар нийт 97 мэдээлэл нийтлэгдсэн бөгөөд хэвлэлийн мэдээ, үйл ажиллагаа, ил тод байдлын мэдээлэл, зөвлөгөө, мэдээ мэдээлэл зэрэг олон төрлийн контент багтсан болно.	100%
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	• 2025 онд сул чөлөөтэй ажлын байрны зарыг байгууллагын гадаад цахим хуудас, ЭМХТ, Хүний нөөцийн мэдээллийн самбар, зангиа.мн сайт, фэйс бүлгэм дээр тус тус 24 удаа шинэчлэн байршуулсан. • Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн сар бүрийн 8-ны дотор тухайн сарын хүний нөөцийн орон тоо, гүйцэтгэлийн мэдээг 2025 онд www.shilendans.gov.mn 12 удаа байршуулсан. 2025 оны 11 сарын гүйцэтгэлээр 1052 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагч ажиллаж байна. Албан тушаалаар авч үзвэл: 263 эмч, 314 сувилагч, 72 эх баригч, дүрс оношилгооны техникч 9, хөдөлгөөн засалч 6, био анагаах судлаач 2, лаборант 22, эм зүйч 14, эм найруулагч 2, туслах сувилагч 30, үйлчлэгч 121, бусад 199 ажиллаж байна. Хүний нөөцийн хангалт 83%. Сувилагч 114 орон тоо дутуу.	100%

2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	• Хүний нөөцийг сонгон шалгаруулахдаа хараат бус, бие даасан нээлттэй ил тод байдлыг баримтлан ажиллаж байна. Эмнэлэг, албадууд нь өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орон тоог Хүний нөөцийн албаар оруулан, Ерөнхий захирлаар батлуулж, хүний нөөцийн төлөвлөлт, сонголтын үйл ажиллагаанд шаардлагатай тухай бүрт ажлын чиг үүргийн дагуу оролцдог. • Ерөнхий захирлын 2023 оны А/142 тоот тушаалаар “ЭХЭМҮТ-д эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан сонгон шалгаруулж авах журам”-ыг шинэчлэн баталсан. • Сонгон шалгаруулалтын журмын дагуу 2025 онд 154 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажилд шалгаруулан авсан байна. • 2025 онд шинээр ажилд орсон ажилчдын мэдээллийг гадаад вэб хуудсанд байршуулсан.	100%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, ёс зүйу талаар хийсэн ажил	• 2025 оны А/17 дугаар тушаалаар ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог байгуулж, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 25/08 дугаар тогтоолоор ЭХЭМҮТ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаанд томилж, баталгаажуулсан. Тушаалыг Төвийн гадаад вэб хуудсанд байршуулсан. • Төрийн албан хаагчийн тухай хуулийг чанд мөрдүүлэх, эмч мэргэжилтэнгүүдэд хуулийг сурталчилах, ёс зүй харьцаа хандлагыг бүх шатанд дээдлэх тухай 7 заалт 4 бүлэг, 18 ажлын төлөвлөгөөг Төвийн захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 2025 оны эхний хагас жилийн ажлын тайланг ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хүргүүлж, тайланг гадаад вэб хуудсанд байршуулсан. • Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр Төвийн гадаад вэб хуудсанд ёс зүйн салбар хорооны гишүүдийн танилцуулга, ёс зүйн дүрэм журмууд, хийх ажлыг төлөвлөгөөг байршуулсан. • Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахаа “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” сэдэвт 2 сарын аяныг 2025.10.23 - 2025.12.23-ны хооронд зохион байгуулахаар удирдамжийг гарган, нийт тасаг	

		нэгжид хүргэж ажиллаж байна. Удирдамжийг гадаад вэб хуудсанд байршуулсан.	
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүний нөөцийн удирдлага, хөгжил, ажилтан албан хаагч нарт үзүүлэх дэмжлэг, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан түүний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. - Хүний нөөцийн алба нь Монгол улсын хууль 9, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журам 6, Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан журам 37, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. 2025 онд хүний нөөцтэй холбоотой буюу В тушаал 490 боловсруулж, батлуулан, тушаал шийдвэрийг PDF хэлбэрээр дотоод цахим сүлжээнд байршуулан ажиллаж байна. - Тус төвийн хэмжээнд олон нийтээрээ дагаж мөрдөх 47 журам, 3 дүрэм, 1 удирдамж, ЭТҮЧА-ны 20, ХНА-ны 55, СА-ны 24, ХЭ-ийн ЯТТ-ийн 31, ЭБЭЭ-ийн ЯТТ-ийн 34 үйл явцын зураглууд, баримт бичгийн 40, тасаг, албадын 55 нэршлийг индексжүүлж, коджуулсан бөгөөд байгууллагын мэдээлэл, баримт бичгийн урсгалыг үр ашигтайгаар удирдах, ашиглах, хянах, хадгалах үйл ажиллагааг боловсронгуй болгож, эмх цэгцтэй байдлыг сайжруулан ажиллаж байна. - Байгууллагын дотоод цахим хуудас болон дотоод сүлжээнд шинэ журам, журамд орсон өөрчлөлт бүрийг тухай бүрт байршуулан, мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажилладаг.	100%
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	- ЭХЭМҮТ-ийн бүтэц орон тоо, удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа зэрэг бүхий л мэдээллүүдийг ил тод гадаад цахим хуудас ehemut.mn болон дотоод сүлжээ, Хүний нөөцийн мэдээллийн телеграмм группт байршуулан, мэдээлж, тухай бүрд баяжилт хийж, нөөцлөл үүсгэн ажиллаж байна. “ЭХЭМҮТ-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” ЭМС-ын 2025 оны А/54 тоот тушаалыг үндэслэн ерөнхий захирлын 2025 оны А/29 тоот тушаалаар төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. - Ерөнхий захирлын 2025 оны А/34 тоот тушаалаар төвийн төсөвт ор, орон тоог батлан гаргасан. Тус төв 2 эмнэлэг, 2 зөвлөх поликлиник, төрөлжсөн мэргэжлийн 32 тасаг, өсвөр үеийн клиник, үргүйдэл нөхөн	100%

		үржихүйн төв, анагаахын удам зүйн лаборатори, Дэмжих үйлчилгээний 20 албатай үйл ажиллагаа явуулж байна. Төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийн тушаалыг гадаад вэб хуудсанд байршуулж мэдээлсэн.	
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлж байх	- Төвийн бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлон, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан улирал бүр 60 хүртэл хувийн урамшуулал олгож байна. “Ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт батлах тухай” ЭХЭМҮТ-ийн захирлын 2025.04.04.-ний А/39 тоот тушаал батлагдан гарсан. Тушаалыг төвийн вэб хуудсанд нээлттэй байршуулж, албан хаагчдад танилцуулсан. - Уг шалгуур үзүүлэлтийн дагуу тасаг, албадын дарга нарын ажлын гүйцэтгэлийг улирал бүр дүгнэж гүйцэтгэлийн үнэлгээгээг дүгнэнэ. 2025 онд ажилчдын ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэн улирал тутамд үндсэн цалингийн 60% хүртэлх хэмжээний урамшууллыг олгож ажилласан. 2025 оны үр дүнгийн урамшуулалд I улиралд 946 ажилтан 733.710.824 төгрөг, II улиралд 913 ажилтан 62764876977 төгрөг, III улиралд 916 ажилтан 597.759.476 төгрөг тус тус олгосон байна.	100%
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хэрэгжилтийн дундаж хувь: 100%			

ТАЙЛАН БИЧСЭН:

Б.МӨНХШҮР /ХНА-НЫ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ/